

## МОНГОЛЫН ШҮҮХИЙН АХМАДУУДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

**Оноосон нэр: Монголын шүүхийн ахмадуудын холбоо**

**/Court veteran association of Mongolia/**

**Товчилсон нэр: МШАХ**

**Хаяг:** Монгол Улс. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр, Харилцах утас: 99115737, 99119864, И-мэйл: [sarantuya0318@yahoo.com](mailto:sarantuya0318@yahoo.com), [mon\\_mcdd@yahoo.com](mailto:mon_mcdd@yahoo.com)

*/2021 оны 12 сарын 20-ны өдрийн хоёрдугаар Их хурлаар өөрчилсөн/*

1.Энэхүү дүрэм нь Монголын шүүхийн ахмадуудын холбооны зорилго, зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл, холбооны бүтэц, хяналтын тогтолцоо, бүрэн эрх, гишүүнчлэл, санхүүжилт, бусад асуудлыг тодорхойлно.

2.Монголын шүүхийн Ахмадуудын холбоо нь ахмад шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдний нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлж ахмад настны тухай хууль тогтоомжийг шүүхийн захиргааны төв, орон нутаг дахь удирдах байгууллагаас хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, хөгжил, нийгмийн оролцоог нь дэмжих, нэгдмэл санал, санаачлага, зөвлөмж, эрэлт хүсэлтийг нь шүүхийн захиргааны байгууллагад уламжлан эргэх холбоог хангах үндсэн зорилго бүхий гишүүн ахмадууддаа үйлчлэх төрийн бус байгууллага /хуулийн этгээд/ мөн.

3.Холбоо нь өөрийн дүрэм, зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Улсын Дээд Шүүхийн тамгын газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын албаны идэвхтэй дэмжлэгт түшиглэн Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн захиргааны ажилтнуудын холбоо, Монголын ахмадын холбоо, Монголын хуульчдын холбоо болон бусад төрийн бус байгууллагатай нягт хамтран ажиллана.

4.Холбоо өөрийн билэгдэл (лого, туг, өөрийн тамга, тэмдэг, санхүүгийн харилцах данс, албан болон бусад баримт бичгийн хэвлэмэл хуудастай байна.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмэлт оруулсан*

5. Төв, орон нутаг дахь шүүхүүдийн дэргэдэх Ахмадын салбар зөвлөл нь тус Холбооны анхан шатны нэгж байх бөгөөд харъяаллын бус ахмадын өөр байгууллага /хороо, зөвлөл, хэсэг г.м/ байгуулахыг хориглоно.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

### **Хоёр: Үйл ажиллагааны үндсэн зарчим**

1.Холбооны зохион байгуулалт нэгдмэл, үйл ажиллагаа нь ардчилсан, ил тод, нээлттэй, гишүүнчлэл нь сайн дурын зарчимд тулгуурлана.

2. Холбоо нь төрийн байгууллагын чиг үүргийг орон гүйцэтгэхгүй, улс төрийн үйл ажиллагаа бие даан явуулахгүй бөгөөд ахмадуудыг ялгаварлахгүй.

3.Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

4.Холбоо нь өөрийн улсын болон гадаадын, олон улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэнэ.

## Гурав. Зорилго.

3.1. Гишүүд дэмжигчдийг эгнээндээ нэгтгэн тэдний нийтлэг эрх, ашиг сонирхолыг төлөөлж ахмад настны тухай хууль тогтоомжийг шүүхийн захиргааны төв, орон нутаг дахь удирдах байгууллагаас хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг үр нөлөөтэй хангаж хамгаалах бодлогыг нь дэмжих, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд ахмад шүүгч, ажилтны хүч, анхаарлыг чиглүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, хөгжил, нийгмийн оролцоог нь дэмжих, нэгдмэл санал, санаачлага, зөвлөмж, эрэлт хүсэлтийг нь шүүхийн захиргааны байгууллагад уламжлан тэдний эргэх холбоог хангах, ахмад настанд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон алив асуудалд ажил хэрэгчээр оролцох нь Монголын шүүхийн Ахмадуудын холбооны зорилго мөн.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

### Дөрөв. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Холбоо нь дараах үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулна.

4.1.1. Шүүхийн захиргааны удирдах байгууллагаас ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, бодлогыг нь дэмжих, зөвлөн туслах,

4.1.2. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах бодлого, шийдвэрийг таниулах, хэрэгжүүлэхэд ахмад шүүгч, ажилтны оролцоог нэмэгдүүлэх,

4.1.3. шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд ахмад шүүгч, ажилтны хүч, анхаарлыг чиглүүлэх,

4.1.4. Ахмад шүүгч, ажилтны нэгдмэл хүсэл сонирхлыг илэрхийлэх, эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь оролцох, санал, санаачлага, зөвлөмж, эрэлт хүсэлтийг шүүхийн захиргааны байгууллагад уламжлан эргэх холбоог хангах,

4.1.5. Ахмад шүүгч, ажилтны хөдөлмөр эрхлэлт, хөгжил, нийгмийн оролцоог нь дэмжих, ялангуяа ахмад шүүгчдийг мэргэшлээрээ үргэлжлүүлэн ажиллах эрх зүйн орчиныг бүрдүүлэхэд анхаарч ажиллах,

4.1.6. Ахмад шүүгч, шүүгч ажилтны ажил, амьдарлын баялаг туршлага, өв уламжлал, ёс заншил, ёс зүй, хөдөлмөрч чанарыг залуу үеийхэнд өвлүүлэн үлдээх, тэдний алтан холбоог бэхжүүлэх,

4.1.7. Шүүхийн захиргааны төв, орон нутаг дахь удирдах байгууллагаас Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-д заасан үүргээ хэрэгжүүлэх, ахмад шүүгч, ажилтнуудад анхаарал халамж, дэмжлэг үзүүлэх явдалд санаачлагч байж, хамтран ажиллах,

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар өөрчилсөн*

4.1.8. Шүүхийн ахмад зүтгэлтэн, хөдөлмөр бүтээлийн алдар цуутнууд болон эрдэмтэн, судлаач, доктор, профессор зэрэг эрдмийн цол зэрэг бүхий ахмад гишүүдийн тэгш насны ой, хөдөлмөр алдрыг тэмдэглэх, урамшил шагнал хүртээх, тэдний туурвисан ном, зохиол оюуны үнэт бүтээлийг хэвлэн нийтлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.1.9. Авъяас чадвартай, бүтээлч ахмадуудын урлаг спортын тоглолт, уралдаан тэмцээн зохион байгуулах.

4.1.10. Шүүхийн захиргааны төв, орон нутаг дахь удирдах байгууллага, төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцаатайгаар ахмад гишүүд, залуучуудын нөхөрсөг уулзалт ярилцлага, сургалт, аялалын арга хэмжээ хамтран зохион байгуулах,

4.1.11. Ахмадуудын эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, амралт сувилалд явуулах, ажлын байр бий болгох, ахуй амьдралд нь туслах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, хамтран ажиллах.

4.1.12. Шүүх, шүүгчийн хараат бус байдал, нэр хүндэд халдсан болон нийгмийн амьдралын бусад тулгамдсан асуудлаар гишүүдийн нэгдмэл ашиг сонирхол, санаачлагыг илэрхийлсэн уриалга, илгээлт, мэдэгдэл болон захидлыг холбогдох байгууллага, олон нийтэд илгээн толилуулах.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

4.1.13. Холбооны дүрмээр тодорхойлогдсон зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх.

4.1.14. Холбооны дотоод, гадаад харилцааг өргөтгөх, олон улсын болон хөрш орнуудын ахмадын болон ижил төстэй байгууллага, холбоодтой ажил хэргийн холбоо тогтоож, хамтран ажиллах.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

4.1.15. Албан ёсны санал гарган Шүүхийн Ерөнхий зөвлөл “Ахмадын сан”-г байгуулах, сангийн хөрөнгөөр ахмад шүүгч, ажилтанд тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх, сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг холбогдох санхүүгийн албатай хамтран зохион байгуулах,

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

4.1.16. Судалгаа, санал гаргах замаар ахмад шүүгч ажилтнуудыг төрийн болон шүүх эрх мэдлийн салбарын шагналд тодорхойлуулах, бусад урамшил үзүүлэхэд санаачлан оролцох,

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

4.1.17. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын алба болон төв, орон нутгийн шүүхүүдэд Ахмадын зөвлөл байгуулах, үйл ажиллагааг нь нэгтгэн зохицуулах,

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

4.1.18. Ахмадын болон гишүүдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, Зөвлөлүүдийн мэдээг нэгтгэх, тайлагнах,

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

#### **Тав: Холбооны бүтэц, хяналтын тогтолцоо:**

5.1. Холбоо нь өөрийн үйл ажиллагааг нээлттэй, хариуцлагатай, гишүүдэд хүртээмжтэй байлгахын тулд дараах бүтэцтэй байна. Үүнд:

5.1.1. Их хурал,

5.1.2. Удирдах зөвлөл

5.1.3. Холбооны тэргүүн, ажлын албаны дарга

5.1.4. Холбооны хяналтын зөвлөл,

5.1.5. Холбооны салбар зөвлөл, Үүнд: Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын алба, төв, орон нутаг дахь шүүхийн тамгын газруудын дэргэд Ахмадын салбар зөвлөлтэй байна.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

5.2. Ахмадуудын холбооны салбар зөвлөлийг нутаг дэвсгэрийн, эсхүл шүүхийн харьяаллаар нэгтгэн байгуулж болно.

5.3. Холбоо нь Ахмад шүүгчдийн дэд хороо, Шүүхийн захиргаа, үйлчилгээний ахмад ажилтнуудын дэд хороо, мөн үйл ажиллагааны чиглэлээр хөдөлмөр эрхлэлт, мэдээлэл, сургалт, сурталчилгааны асуудал эрхэлсэн, эрүүл мэнд, аялал, спортын асуудал эрхэлсэн ажлын хэсгүүдтэй байж болно.

#### **Зургаа. Их хурал**

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

6.1. Их хурал нь тус холбооны эрх барих дээд байгууллага мөн.

6.2. Их хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байж болно.

6.3. Их хурлыг 3 жилд 1 удаа хуралдуулна.

6.4. Ээлжит бус их хурлыг Холбооны тэргүүний санал, эсвэл удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүсэлт гаргавал зарлан хуралдуулж болно.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

6.5. Ээлжит болон ээлжит бус их хурлыг цахимаар болон харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглан хийж болно.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

6.5. Ээлжит болон ээлжит бус их хурлын бэлтгэлийг ажлын албаны дарга, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албаны даргатай хамтран зохион байгуулна.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

6.6. Их хурал дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.6.1. Холбоог өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг тогтоох, татан буулгах,

6.6.2. Холбооны дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах,

6.6.3. Холбооны удирдах зөвлөл болон хяналтын албаны бүрэлдэхүүнийг сонгох,

6.6.4. Холбооны тэргүүнийг сонгох, чөлөөлөх,

6.6.5. Холбооны ажлын тайлан хэлэлцэх, мэдээлэл сонсох,

6.6.6. Холбооны хяналтын албаны тайлан хэлэлцэх, мэдээлэл сонсох.

6.6.7. Гишүүдийн **хуримтлал**ын хэмжээг тогтоох, өөрчлөх,

6.6.8. Дүрэмд заасан бусад бүрэн эрх болно.

6.7. Их хурал хуралдуулах тов, хэлэлцэх асуудлыг удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр тогтооно.

6.8. Их хурал нь салбар зөвлөлийн гишүүдийн төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд гишүүдийн тооноос хамаарч 6 хүн тутмаас 1 төлөөлөгчийг сонгож оролцуулна. Сонгогдсон төлөөлөгч тухайн холбооны гишүүдийг бүрэн төлөөлнө.

6.9. Их хурал нь төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдох бөгөөд бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана.

6.10. Хурал дэгээ өөрөө тогтоож, хурлын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.

6.11. Их хурлын тогтоолд хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар өөрчилсөн/*

### **Долоо. Холбооны Удирдах зөвлөл.**

7.1. Удирдах зөвлөл нь Холбооны тэргүүн, ажлын албаны дарга болон бусад таваас дээшгүй гишүүдээс бүрдэх бөгөөд орон тооны бус байна.

7.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг бүх гишүүдийн хурлаас 3 жилийн хугацаагаар сонгоно.

7.3. Удирдах зөвлөлийн хурлыг жилд дөрвөөс доошгүй удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд Холбооны тэргүүний шийдвэрээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.

7.4. Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахимаар болон харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглан хийж болно.

7.5. **Удирдах зөвлөлийн гишүүнийг энэ дүрмийн 7.5.2-д заасан үндэслэлээр чөлөөлөх, тийнхүү чөлөөлсөн, орон гарсан тохиолдолд гишүүнийг нөхөн сонгох,**

*/нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа Холбооны тухайн Их хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчинтэй байна./*

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

7.6. Удирдах зөвлөлийн гишүүнийг Их хурлаас нэрийг нь дэвшүүлж, төлөөлөгчдийн олонхийн саналаар сонгоно.

7.7. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараахь үндэслэлээр чөлөөлнө:

а/ Сайн дураараа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан,

б/ Холбооны дүрмийг гажуудуулсан, ашиг сонирхлын зөрчилд автсан гэж үзэх үндэслэл бүхий бол,

в/ Удирдах зөвлөлийн хурлыг хүндэтгэх шалтгаангүйгээр хоёр, түүнээс дээш удаа тасалсан, хариуцсан ажил үүргээ удаа дараа хангалтгүй гүйцэтгэсэн,

7.8. Зөвлөлийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол удирдах зөвлөлийн гишүүн байх бүрэн эрх нь тус тус дуусгавар болно.

7.9. Удирдах зөвлөлийн хуралд нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдох бөгөөд хуралдаанд оролцогчдын олонхын саналаар асуудлыг шийдвэрлэж тогтоол, тэмдэглэл гаргана.

7.10. Удирдах зөвлөлийн хурлын тогтоолд Холбооны **тэргүүн гарын үсэг зурж тамга дарж** баталгаажуулна.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

7.11. Удирдах зөвлөл дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.11.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, татан буулгах саналыг их хуралд оруулах

7.11.2. Холбооны тухайн жилийн ажлын үндсэн чиглэл, төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.

7.11.3. Их хурлыг зарлан хуралдуулах

7.11.4. Ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх

7.11.5. Гишүүдийг шагнаж урамшуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

7.11.6. Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, төсвийг батлах

7.11.7. Шаардлагатай гэж үзвэл холбооны үйл ажиллагааны чиглэлээр “хороо”, “хэсэг” байгуулж болно.

7.11.8. Удирдах зөвлөлийн зарим бүрэн эрхийг холбооны Тэргүүнд шилжүүлэх

7.11.9. Холбооны ажлын албаны дарга, орон тооны бус нарийн бичгийн дарга, санхүү хариуцсан ажилтнаас бүрдсэн ажлын албыг байгуулж болно.

7.11.10. **Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах, тайлан гаргуулах, нэгтгэх, Зөвлөлийн тэргүүний сонгол мэдээллийг хэлэлцүүлэх, ажлыг дүгнэх шалгаруулах,**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

**7.11.11. Холбооны үйл ажиллагаанд мөрдөгдөх удирдамж, заавар, журам, бүртгэл маягтууд / гишүүдийн, шагнал урамшлын, хуримтлалын г,м/ боловсруулж батлах**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

7.11.12. Удирдах зөвлөлийн гишүүд, ажлын албаны дарга, нарийн бичгийн даргын ажил үүргийн хуваарийг хэлэлцэн батлах,

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар нэмсэн/*

7.11.13. Дүрэмд заасан бусад бүрэн эрх.

7.12. Удирдах зөвлөл нь их хурлын чөлөө цагт түүний зарим бүрэн эрх /удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, орон гарсан гишүүнийг нөхөн сонгох г.м/-ийг хэрэгжүүлж болно.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

### **Найм. Холбооны тэргүүн.**

- 8.1. Холбооны Тэргүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.Үүнд:
- 8.2.Холбоог ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах,
- 8.3. Холбоог дотоод гадаадад төлөөлж, холбооны нэрийн өмнөөс шүүхийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагатай холбоо тогтоох, харилцах,
- 8.4.Удирдах зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулах, хуралдааныг даргалах
- 8.5. Холбооны үйл ажиллагааны чиглэл /төлөвлөгөө/ -ний хэрэгжилтэд хяналт тавих,
- 8.6.Удирдах зөвлөл, хяналтын албаны бүрэлдэхүүнийг өөрчлөх, нөхөн сонгох талаар их хуралдаанд санал оруулах, хэлэлцүүлэх
- 8.7.**Ажлын албаны даргын нэрийг дэвшүүлж, сонгогдсон Ажлын албаны даргатай гэрээ** байгуулах, түүнд **даалгавар** өгөх,
- 8.8. Холбооны мөнгө санхүүг хуримтлуулж, арившуулах арга хэмжээг зохион байгуулах.
- 8.9. Удирдах Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийг хуваарилах,
- 8.10. Төв, орон нутгийн шүүх дэх ахмадын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн салбар зөвлөлийн тэргүүнийг батламжлах,

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

**8.11.Холбооны тэргүүн бүрэн эрхийн асуудлаар тушаал гаргана.**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

### **Ес. Ажлын албаны дарга**

- 9.1. Холбооны ажлын албаны дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ
  - 9.1.1. **Холбоо түүний ажлын албыг** өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллана.  
*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*
  - 9.1.2.Холбооны жилийн ажлын үндсэн чиглэл /төлөвлөгөө/ боловсруулж, батлуулах, биелэлт, гүйцэтгэлийг зохион байгуулж хангах болон дотоод ажлыг бүхэлд нь хариуцна,
  - 9.1.3. Холбооны их хурлын болон удирдах зөвлөлийн хурлын бэлтгэл **ажлыг хангах, шийдвэрийн хэрэгжилтийг** зохион байгуулах, **хуралдааны тэмдэглэл хөтлөж албажуулах**  
*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*
  - 9.1.4. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх
  - 9.1.5. Холбооны салбар зөвлөл, гишүүдийн **нэгдсэн** бүртгэл, судалгаа болон бусад бичиг баримтыг бүрдүүлэх, хадгалах, хөдөлгөөн хийх, архивлах.  
*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*
  - 9.1.6. Холбооны албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга тэмдгийг хариуцаж хадгалах, албан хэрэгцээнд хэрэглэх.
  - 9.1.7. Холбооны сан, хандив, бусад орлогоос бүрдсэн мөнгөн хөрөнгийг тухайн жилд батлагдсан хэмжээнд **удирдах зөвлөлийн хуралдааны тогтоол болон Холбооны тэргүүний шийдвэрийг үндэслэн** захиран зарцуулна.  
*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*
  - 9.1.8. Санхүү хариуцсан ажилтан /ня-бо/-ыг гэрээгээр ажиллуулах.
  - 9.1.9. Салбар зөвлөлүүдийн болон гишүүдийн хуримтлалын мэдээг нэгтгэх, дүнг Удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулах,  
*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар нэмсэн/*



- 9.1.10. Дүрэмд заасан бусад бүрэн эрх болно.
- 9.2. Холбооны ажлын албаны дарга нь орон тооны ажилтан байна.

### **Арав. Холбооны салбар зөвлөл.**

- 10.1. Шүүхийн Ерөнхий Зөвлөл, түүний харъяа шүүхийн тамгын газрууд, ажлын албад нь Ахмадын салбар зөвлөлтэй байна.
- 10.2. Ахмадын салбар зөвлөлийн тэргүүнийг Зөвлөлийн бүх гишүүдийн хуралдаанд оролцогчдийн олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно.
- 10.2.1. Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг тухайн шүүхийн тамгын газар, албадын дарга нар зохион байгуулна.
- 10.2.2. Салбар зөвлөлийн бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор Зөвлөлийн хуралдаан хүчинтэйд тооцогдох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж тэмдэглэл үйлдэнэ.
- 10.2.3. Салбар зөвлөлийн хурал хийх тов, хэлэлцэх асуудлыг Салбар зөвлөлийн тэргүүний шийдвэрээр тогтооно.
- 10.2.4. Зөвлөлийн хурал дэгээ өөрөө тогтоож, хурлын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.
- 10.2.5 Салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 10.2.6. Холбооны салбар зөвлөлийн хурлыг жилд хоёроос доошгүй удаа зарлан хуралдуулна.
- 10.3. Холбооны 20-иос дээш гишүүнтэй Салбар зөвлөл нь тэргүүлэгч гишүүдтэй байж болно.
- 10.4. Салбар зөвлөл нь их хурал, Удирдах зөвлөл, Холбооны тэргүүний гаргасан шийдвэр, зөвлөмжийг салбар зөвлөлийн хүрээнд зохион байгуулж, жил бүр ажлын төлөвлөгөөтэй ажиллана.
- 10.5. Шүүхийн ахмадуудын холбооны салбар зөвлөлийн орон байр болон үйл ажиллагаа явуулах бусад нөхцлийг тухайн шүүхийн тамгын газар хангах ба Салбар зөвлөл нь доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 10.5.1. Шүүхийн тамгын газар, албатай хамтран Холбооны их хурал, Удирдах зөвлөл, Холбооны тэргүүний гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг Салбар зөвлөлийн хэмжээнд зохион байгуулж, жил бүр ажлын тайлан ирүүлнэ.
- 10.5.2 Гишүүний хуримтлалыг сар бүр хурааж холбооны дансанд төвлөрүүлнэ.
- 10.5.3.Гишүүдээс гаргасан нэгдмэл санал хүсэлтийг нэгтгэн холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээж шийдвэрлүүлнэ.
- 10.5.4. Гишүүдийн дэлгэрэнгүй судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, Холбооны ажлын албанд ирүүлэх ба Дүрмийн “Дөрөв”-т заасан Холбооны үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд санаачлага гаргаж, идэвхтэй ажиллана.
- 10.6.Салбар зөвлөлийн тэргүүн нь баталгааны тэмдэгтэй байж болно. Тэмдгийн загварыг Удирдах зөвлөлийн хуралдаанаас батална.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

### **Арван нэг. Хяналтын алба.**

- 11.1. Хяналтын алба нь МШАХ-ны дүрэм, Их хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө санхүүгийн зарцуулалт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавина.
- 11.2. Холбооны тэргүүн, зөвлөлийн гишүүн, түүнчлэн гэрээт ажилтныг Хяналтын албаны гишүүнээр сонгохгүй.

11.3. Хяналтын алба жилд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хэдийд ч хуралдаж болно.

11.4. Хяналтын алба нь үйл ажиллагаандаа холбогдох аливаа мэдээ, бичиг баримтыг саадгүй гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүнийг хяналтын ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.

11.5. Хяналтын алба нь 3 хүртэл гишүүнтэй байна.

11.6. Хяналтын алба илэрсэн дутагдлыг тухай бүр их хурал болон Удирдах зөвлөлд мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авахуулна.

11.7. Хяналтын алба нь бүрэн эрхэд хамаарах асуудлаараа дүгнэлт гаргана.

### **Арван хоёр. Холбооны гишүүнчлэл**

12.1. Холбоо нь гишүүнчлэлтэй байна. Энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаанд нь оролцохыг эрмэлзэгч тэтгэвэрт гарсан шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, бусад ахмадууд холбооны гишүүнд хамрагдана. Холбооны гишүүд нь заавал бүртгэгдсэн байна.

12.2. Холбооны дүрэм, зорилгыг хүлээн зөвшөөрсөн шүүхийн байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадууд гишүүнчлэлд хамрагдах эрхтэй.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн*

12.3. Холбооны гишүүн дараах эрхтэй байна:

12.3.1. Холбооны бүх шатны удирдах байгууллагад сонгох, сонгогдох, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох,

12.3.2. Холбооны удирдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, холбооны гишүүдийн өмнө тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд идэвхтэй оролцож, үзэл бодлоо илэрхийлэх,

12.3.3. Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасны дагуу эрхээ хамгаалуулах, дэмжлэг туслалцаа хүсэх,

12.3.4. Өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс татгалзах зэрэг болно.

12.4. Холбооны гишүүн дараах үүрэгтэй байна:

12.4.1. Холбогдох хууль, холбооны дүрмийг хэрэгжүүлэх,

12.4.2. Тогтоосон журмын дагуу сар бүр хуримтлал төлөх

12.4.3. Холбооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох

12.4.4. Холбооны санд мөнгө, хөрөнгө хандивлах, санхүүгийн чадвахийг нэмэгдүүлэхэд идэвхи санаачлага гарган оролцох.

12.5. Холбооны гишүүнээр элсэх болон гарахад доорхи журмыг баримтлана:

12.5.1. Гишүүнээр элсэхийг хүсэгч энэхүү дүрэмд заасан эрх үүргийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлж, гишүүнээр элсэх тухай хүсэлтээ Холбооны салбар зөвлөлд гаргана.

12.5.2. Салбар зөвлөлийн тэргүүн хүсэлтийг хүлээн авч гишүүний **нэгдсэн** бүртгэлд бүртгэснээр Холбооны гишүүн болно.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

**Шинээр элссэн гишүүнд гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдэг олгоно.**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

12.5.3. Дараах тохиолдолд гишүүнээс гарна:

а/ гишүүнчлэлээс татгалзах, гарах тухай хүсэлтээ Холбооны салбар зөвлөлд бичгээр гаргасан,

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар өөрчилсөн/*

б/ холбооны санд төвлөрүүлэх хуримтлалаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 /нэг/ жилээс дээш хугацаагаар өгөөгүй.

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар Их хурлаар өөрчилсөн/*



12.6. Гишүүн алив өргөдөл, хүсэлт, санал гаргахдаа харъяа Салбар зөвлөлдөө хандаж уламжлуулна.

### **Арван гурав. Холбооны санхүүжилт.**

13.1. Холбоо нь өөрийн мөнгөн болон бусад эд хөрөнгөтэй байна.

13.2. Холбооны эд хөрөнгө доорхи эх үүсвэрээс бүрдэнэ.

13.2.1. Гишүүний **хуримтлал, хуримтлалын хувь хэмжээг** Холбооны их хурлаар хэлэлцэн **тогтоох ба шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөн тогтоож, Их хуралд танилцуулж болно. Гишүүний хуримтлал төвлөрүүлэх, хөнгөлөх, чөлөөлөх журмыг Удирдах зөвлөлийн хуралдаанаар батлана.**

**Гишүүн сар бүр хуримтлал төвлөрүүлнэ.**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар нэмсэн/*

13.2.2. Иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын хандив, дэмжлэг,

13.2.3. Дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдуулан аж ахуй болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого,

13.2.4. Зээл, хадгаламжийн хүү, ахмад настны тухай хуулийн дагуу байгуулсан ахмадын сан, төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө.

13.2.5. Гадаадын болон олон улсын байгууллагын хандив, тусламж.

13.3. Холбооны **мөнгөн санхүү** болон **бусад эд хөрөнгийг зөвхөн дүрэмд** заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд **зарцуулна**. 1 дүгээр гарын үсгийг холбооны **ажлын албаны дарга**, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч зурна.

*/2021 оны 12 дугаар 20-ны өдрийн 2-р их хурлаас орсон өөрчлөн найруулсан/*

13.4. Холбооны тэргүүн, ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: /2 дугаар их хурлаас өөрчлөлт оруулсан/

13.4.1. Холбооны орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуй нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах

13.4.2. Ахмадын сангийн хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулах,

13.4.3. Сонгуулийн үйл ажиллагаанд буюу нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөх зэрэг болно.

13.5. Холбоо нь санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор харьяалах Татварын алба болон бусад холбогдох байгуулагад гаргаж өгнө.

### **Арван дөрөв. Гишүүнчлэлээс сайн дураар татгалзах, чөлөөлөх, гишүүнчлэлээ сэргээх.**

14.1. **Гишүүнээс татгалзах хүсэлтээ бичгээр үйлдэж, харъяа салбар зөвлөлийн тэргүүнээр уламжлуулан холбооны ажлын албанд ирүүлнэ. Хүсэлтийг холбооны тэргүүн шийдвэрлэж, тушаал гарган нэгдсэн бүртгэлээс хассан тухай салбар зөвлөлд мэдэгдэнэ, Амаар ирүүлсэн хүсэлтийг хүлээж авахгүй.**

*/Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

14.2. Гишүүн нь **хуримтлалаа** удаан хугацаагаар төлөөгүй, байгууллагын нэр хүндийг унагасан, ашиг сонирхолын зөрчилд автсан зэрэг тодорхой шалтгаан, нөхцөл бүрдсэн гэж үзвэл гишүүнчлэлээс чөлөөлөх эсэхийг Холбооны салбар зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн*

14.3. **Гишүүнтэй холбоотой гаргасан гомдол, саналыг Салбар зөвлөл судалж, энэ тухай саналаа ажлын албанд ирүүлнэ.**

*Холбооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар их хурлаар өөрчилсөн/*

14.4. Холбооны гишүүнчлэлээ сэргээх, элсэхэд урьд нь гаргасан үйлдэл, эс үйлдэхүй үл хамаарна.

**Арван тав. Монголын шүүхийн Ахмадуудын холбооны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Шүүхийн Ерөнхий зөвлөл, шүүхийн захиргааны удирдах байгууллагын хүлээх үүрэг:**

15.1. Холбооны тэргүүн, түүний ажлын албыг үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өрөө, тасалгаа, интернет цахим тоног төхөөрөмжөөр хангаж, шаардлагатай үед унаа машинаар туслах,

15.2. Холбооны бүх гишүүдийн болон удирдах зөвлөлийн хуралдаан явуулах бэлтгэлийг хангах, шаардагдах дүрэм, журмуудыг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,

15.3. Ахмадын өдөр, уламжлалт цагаан сарын баяраар ахмад настныг төрийн болон шүүх эрх мэдлийн байгууллагын болон бусад шагналаар нөхөн шагнах, урамшуулах тогтолцоог өргөтгөх,

15.4. Ахмад настны тухай хууль /2017 он/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-д заасны дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэд “төсөвт цалингийн гурав хүртлэх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгаж”, хууль журамд заасан арга хэмжээнд зарцуулах нөхцлийг хангах,

15.5. Ахмад шүүгчдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, тэднийг шүүгч мэргэшлээрээ үргэлжлүүлэн ажиллах эрх зүйн орчин нөхцлийг бүрдүүлэх,

15.6. Орон нутгаас нийслэлд шилжин ирж тодорхой харъяалалгүй болсон ахмад шүүгч, ажилтнуудыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн болон нийслэл, дүүргийн шүүхийн Ахмадуудын зөвлөлд тус тус харъяалуулан бүртгэлжүүлж, хяналт тавих.

15.7. Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс төв, орон нутаг дахь шүүхийн тамгын газрын дарга нарын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ ахмад шүүгч, ажилтнуудын дунд зохион байгуулж авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Ахмад настны тухай хуулиар хүлээсэн захиргааны үүргийг хэрхэн биелүүлж ажилласан байдлыг харгалзах үзүүлэлт болгон шалгаруулдаг журам тогтоон хэрэгжүүлэх,

15.8. Шүүхийн багц хуулиуд болон Шүүх байгуулах тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Холбооны болон ахмад шүүгчдийн саналыг тусгаж байх,

15.9. Шинэ залуу шүүгчдийн сургалт, ажлын дадлагажилт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээнд ахмад шүүгчдийн хүчийг нэгтгэн чиглүүлэх.

**Арван зургаа. Бусад асуудал**

16.1. Холбоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу татан буулгаж болно.

16.2. Холбоо татан буугдсан тохиолдолд хөрөнгийг энэхүү дүрэмд заасан зорилгод бүрэн зарцуулж, дуусгалтын тайлан гаргана.

16.3. Холбоо нь гишүүн болон бусад сонгуультны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон эд хөрөнгийн болон бусад хариуцлагыг хүлээхгүй

16.4. Холбоо нь өөрийн нэрэмжит шагналтай байж болно.

16.5. Дүрэм батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр.

Улаанбаатар хот.